

АРХАНГАЙ АЙМГИЙН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫН  
2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ  
/Жилийн эцсийн байдлаар/

2023.03.11

№	ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ	БИЕЛЭЛТ
1	ОУИТБС-ын дэд зөвлөлийн хурлыг зохион байгуулах	Дэд зөвлөлийн хурлыг 2 удаа зохион байгууллалаа. Олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачлагыг дэмжих ажлын хүрээнд дэд зөвлөлийн албан хаагчид олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачлагын ажлын албанаас болон Ашигт малтмал, газрын тосны газраас зохион байгуулсан 3 удаагийн сургалтад хамрагдлаа.
2	Орон нутгийн төсөвт хүлээн авсан татвар, төлбөр, хандив дэмжлэгийн мэдээг гарган, санхүү татварын мэдээлэлтэй тулган баталгаажуулсны үндсэн дээр программд шивж оруулан нэгдсэн дүнг ОУИТБС-ын ажлын албанд хугацаанд нь хүргүүлэх	Архангай аймагт Ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулж буй “БМНС” ХХК 2023 онд газрын төлбөрт 49,916,356 төгрөг, “Ашид бэхи” ХХК нь Үл хөдлөх эд хөрөнгө, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн, газрын, ус бохирдуулсны, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, хог хаягдал үйлчилгээний хураамж нийт 26,654,804 төгрөг, “Цагаан сүмбэр” ХХК нь Үл хөдлөх эд хөрөнгө, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн, газрын, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нийт 1,151,301 төгрөг, “Бодь Ар” ХХК түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 1,476,500 төгрөгийн татварыг төлсөн байна.
3	Орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын ашигт малтмалын хайгуул, олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй компаниудаас нийгмийн хариуцлагын хүрээнд хүлээн авсан мөнгөн болон мөнгөн бус хандивыг олон нийтэд мэдээллэх ажлыг холбогдох хуулийн дагуу зохион байгуулах	2023 онд бичил уул уурхайгаар ашигт малтмал олборлоогүй байна. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Ашид бэхи” ХХК нь тухайн онд нийгмийн хариуцлагын хүрээнд нийт 192,666,081 төгрөгний хандив, тусламж өгсөн байна.
4	Байгаль орчны нөхөн сэргээлтийн гүйцэтгэлийн талаарх авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээ, тайланг аж ахуйн	Аймгийн дэд ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж, ажлын хэсгийн төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг хангаж ажиллаа. Цэнхэр сумын Орхон багт ашигт малтмалын ашиглалтын MV-001410 тоот тусгай зөвшөөрөл

	нэгж бүрээр гаргах	<p>эзэмшигч “БМНС” ХХК-аар өөрийн тусгай зөвшөөрлийн 8 га талбайд биологийн, MV-5529 тоот тусгай зөвшөөрөл эзэмшигч “Батдөлгөөн мөрөн” ХХК-аар 8 га талбайд техникийн, Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын MV-65000039 тоот тусгай зөвшөөрөл эзэмшигч “Бодь-Ар” ХХК-аар дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд 1 га талбайд техникийн, MV-65000035 тоот тусгай зөвшөөрөл эзэмшигч “Ашид бэхи” ХХК-аар тусгай зөвшөөрлийнх нь 1 га техникийн, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд 2.2 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг тус тус хийж гүйцэтгүүллээ.</p>
5	<p>Компаниуд болон туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжээс 2023 онд орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр, хураамж, үйлчилгээний хөлс, ногдол ашиг, торгууль, хандив, тусламж, байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардалд хяналт тавих</p>	<p>“Ашид бэхи” ХХК-аар 500 ширхэг, “Бодь ар” ХХК-аар Булган сумын Авхайн булагт 500 ширхэг шилмүүст модыг тариулж, ургалтын хувь 87 хувьтай байна. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Ашид бэхи” ХХК-аас бусад тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжүүд үйл ажиллагаа явуулахад шаардагдах баримт бичгийн бүрдэл хангаагүй тул энэ онд үйл ажиллагаа явуулаагүй байна. “Ашид бэхи” ХХК нь тухайн онд нийгмийн хариуцлагын хүрээнд нийт 192,666,081 төгрөгний хандив, тусламж өгсөн байна.</p>